

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ /2023.06.22/**

2023 оны 06 сарын 22

Арвайхээр

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг тоо баримтаар товч бичих	Байгуулл агын үнэлгээ	Аймгийн ЗДТГ-аар үнэлгээ
1	<p>Зорилт: Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг “Санхүүгийн хяналт, аудитын алба” фэйсбүүк болон www.sankhuuliyanalт.ов.gov.mn хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэх</p> <p>1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах</p> <p>1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах</p> <p>1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонин) нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.</p>	<p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн “Үйлийн үр хаяг андуурдаггүй” шторкийг 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр албаны “Санхүүгийн хяналт, аудитын алба” гэсэн фэйсбүүк хуудсанд байршуулж олон нийтэд хүргэсэн.</p> <p>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж байгаа “Нэгдье” арга хэмжээнд манай алба оролцож, албаны фэйсбүүк хуудасны профайл зургийг арга хэмжээний лого бүхий зургаар өөрчлөн, холбогдох мэдээллүүдийг байршуулан, авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээнд идэвхтэй оролцлоо.</p> <p>Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар, буланг албаны мэдээллийн самбарт байршуулж ажиллаж байна.</p> <p>Санхүүгийн хяналт шалгалт болон дотоод аудит хийсэн байгууллагуудын албан хаагчдаас хэрэглэгчийн судалгаа авдаг бөгөөд энэ онд судалгааны асуулгад Авлигаас ангид байж хяналт шалгалт нээлттэй, ил тод явагдаж чадсан уу? Тийм, үгүй гэдэг сонголттой, үгүй гэвэл яагаад гэдэг тайлбартайгаар оруулж, судалгааг авч байна.</p>	100	

	<p>2.1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх</p>	<p>Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагч байхгүй.</p>	100	
<p>2</p> <p>Авлигын эсрэг зохион байгуулах, сургалтад хамруулах</p>	<p>2.2. Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (Тухайлбал, тусгай зөвшөөрөл төлөөлөгч, эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд сурталыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.</p>	<p>Манай алба нь Орон нутгийн төсвийн-166, Төрийн сан-20,ОНӨААТГ, ОНӨҮГ-11, Нөхөрлөл-4, нийт 201 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилт, үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдалд улирал тутам хяналт тавин ажиллаж, шалгалтын мэдээллийг <a href="http://www.sankhuidhуanaalт.ov.gov.mn">www.sankhuidhуanaalт.ov.gov.mn</a> цахим хуудсанд аа байршуулан ажиллаж байна.</p>	100	
<p>3</p> <p>Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох</p>	<p>3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.</p> <p>3.2. "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх.</p>	<p>Гэрээ байгуулаагүй байна.</p> <p>Журмын хэрэгжилтийг ханган албаны <a href="http://www.sankhuidhуanaalт.ov.gov.mn">www.sankhuidhуanaalт.ov.gov.mn</a> цахим хуудсанд хяналт шалгалт, дотоод аудитын төлөвлөгөө, ажлын тайлан, танилцуулга, үйл ажиллагааны мэдээлэл, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг тухай бүр нь шилэн дансанд хуулийн дагуу мэдээллүүдийг байршуулж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна.</p>	100	
<p>4</p> <p>Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах</p>	<p>4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол</p>	<p>2023 онд албаны даргын тушаал шийдвэртэй холбоотой 2, дотоод аудит, хяналт шалгалттай холбоотой 39 Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг</p>	100	

	<p>Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м)</p> <p>4.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх.</p> <p>4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.</p>	<p>гаргуулан бүртгэл хяналтын дэвтэрт бүртгэж сар бүр шилгэн дансанд байршуулж, <a href="http://www.sankhuichuanaif.gov.tml/">http://www.sankhuichuanaif.gov.tml/</a> цахим хуудасны "ил тод" цэсний "авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" хэсэгт сар бүр байршуулсан. <a href="mailto:Meduleg.iaas.tml">Meduleg.iaas.tml</a> цахим хуудсанд мэдээллийг тухай бүр оруулсан.</p> <p>Эхний хагас жилд хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулаагүй байна.</p>	-	
5	<p>Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх</p> <p>5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1 дүгээр улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчиддаа танилцуулах.</p> <p>5.2. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүрэм, журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусган, хэрэгжүүлэх.</p>	<p>Албаны 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, албаны даргаар батлуулан, <a href="http://www.sankhuichuanaif.gov.tml">www.sankhuichuanaif.gov.tml</a> цахим хуудасны "ил тод" цэсний "авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" гэсэн талбарт 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр байршуулсан. Эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг гарган цахим хуудсанддаа байршууллаа.</p> <p>Эхний хагас жилд санал, зөвлөмж ирээгүй байна.</p>	100	
6	<p>Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас</p>	<p>Авлигын эсрэг сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сурталч багшаар дамжуулан</p> <p>2023 оны 06 дугаар сарын 21-нд аймгийн Авлигатай тэмцэх газартай хамтран ЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан</p>	100	

урьдчилан сэргийлэх, соён тэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг төлөвлөн, тайлагнах	хүүхэд залуучуудад хүргэх үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар, Боловсрол, Шинжлэх ухааны газар, Монголын Хуульчдын холбооны аймаг дахь салбар зэрэг байгууллагуудтай хамтран шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах	Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтын үйл ажиллагаанд манай албанаас 4 улсын байцаагч, албаны нягтлан бодогч нар оролцож, авлигын эсрэг "Нэгдье" арга хэмжээнд оролцов.		
---	--	--	--	--

АЛБАНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ЛХАМДОЛГОР

ХЯНАСАН:  
БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



С.ДУЛАМЖАРГАЛ